

УУЛ УУРХАЙН ЯАМНЫ 2016 ОНЫ АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Дэд хэсэг	Хийх ажлын агуулга	Гүйцэтгэлийн үзүүлэлт	Биелэлт
1	<p>Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, энэ талаархи мэдээллийг иргэд, байгууллага чөлөөтэй авах нөхцөлийг хангах</p> <p>Эрх зүйн үндэслэл:</p> <ul style="list-style-type: none"> • Авлигын эсрэг хууль 5 дугаар зүйлийн 5.1.2; • Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.5; • Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2. 	<p>1.1. Авлигын эсрэг хууль тогтоомжийг боломжит хэл-бэрээр сурталчлах /мэдээллийн самбар, цахим хуудас, теле сурталчилгаа, яриа та-ниулга, сонголт, нээлттэй өдөрлөг, хэлэлцүүлэг, хэвлэмэл материал г.м/</p>	<p>Авлигын эсрэг хууль, Нийтийн албан хувийн ашиг сонирхлыг зохицуулах болон ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх хууль, УИХ-ын Хууль зүйн байнгын хорооны 2014 оны 20 дугаар тогтоол, Хууль зүйн байнгын хорооны тогтоол зэрэг авлигын эсрэг хууль, тогтоомжийг яамны цахим хуудас /mmhi.gov.mn/-ны “Авлигын эсрэг хамтдаа” цэс болон мэдээллийн самбарт байршуулж, Яамны ажилтнуудад “Мэдүүлэг гаргагч нарт зориулсан сургалт” “Авлигаас урьдчилан сэргийлэх асуудлаар” 2 удаагийн сургалтыг АТГ-ын Хяналт шалгалт, дүн бүртгэлийн хэлтсийн ажилтан комиссар Н.Мөнхбаяр, Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсийн ажилтан комиссар Ж.Сарангэрэл нар явуулсан. Мөн Авлигатай тэмцэх газраас зохион байгуулсан сургалт, семинарт яамны ЭБАТ болон яамны албан хаагчдыг тогтмол хамруулж байна. Сургалт семинарийн үеэр өгсөн гарын авлага материалыг яамны удирдлагуудад танилцуулж өгсөн. Долоо хоног бүрийн 5 дахь өдөр нийт ажилтнуудад сургалт, мэдээллийг өгдөг. Мөн гарын авлага, тараах материалуудыг гаргаж мэдээллийн самбарыг тогтмол байршуулж байна. Яамны вэб сайтын хууль тогтоомж гэсэн цэс дотор салбарын бүх хууль, бодлогын бичиг баримтууд, УИХ-ын болон Засгийн газрын тогтоол, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын тушаал, Төрийн нарийн бичгийн даргын тушаал, мөрдөж байгаа дүрэм журмуудыг байршуулсан.</p> <p>Шинээр батлагдсан Ашигт малтмалын тухай хуульд</p>

			<p>нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль", Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль", "Газрын тосны тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль"-д нийцүүлэн зарим журам дүрмийг шинээр боловсруулж Засгийн газраар батлуулах ажил яам, агентлагын түвшинд хийгдэж байна. 2016 онд Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч болон нутгийн захиргааны байгууллагын хооронд байгуулах "Байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх тухай гэрээ"-ний загварын төслийг Уул уурхайн яамны үед m.gov.mn сайтад байршуулан иргэд, ТББ-уудын төлөөллөөс санал авч Засгийн газрын 2016 оны 3 дугаар срын 28-ны өдрийн 179 дүгээр тогтоолоор батлуулсан. Уг гэрээний төслийг боловсруулах ажлын хүрээнд 2015-2016 онд яам, агентлаг, мэргэжлийн холбоод, ТББ-уудын төлөөллийг оролцуулсан 7 удаагийн уулзалт, семинар, хэлэлцүүлгийг зохион байгуулсан. Уул уурхай, газрын тосны салбарын хэмжээнд "Орон нутгийг хөгжүүлэх хамтын ажиллагааны загвар гэрээ"-ний хэлэлцүүлгийг Уул уурхайн яам, Дэлхийн банкны уул уурхайн дэд бүтэц, хөрөнгө оруулалтын төсөлтэй хамтран Улаанбаатар хот болон Өмнөговь, Төв, Дорноговь аймгуудад зохион байгуулсан байна.</p> <p>Хэлэлцүүлэгт ашигт малтмалын тусгай зөвшөөрөл бүхий аймаг, сумдын 150 орчим төлөөлөл, уул уурхайн 60 орчим компаниуд болон иргэний нийгмийн байгууллагын төлөөлөл оролцсон байна. Үүний үр дүнд Газрын тосны тухай хууль шинэчлэн батлагдсантай холбогдуулан уг хуулийн 7.1.13-т "Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь байгаль орчныг хамгаалах, орон нутгийн хөгжилд сайн дурын</p>
--	--	--	---

			<p>үндсэн дээр дэмжлэг үзүүлэх асуудлыг тусгасан гэрээний загвар”-ыг Засгийн газар батлахаар заасны дагуу гэрээний загварын төслийг “Гэрээний загвар батлах тухай” Засгийн газрын тогтоолын төслийн хамт боловсруулан Засгийн газрын 2015 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж батлуулсан.</p> <p>Яамны цахим хуудсанд Шилэн дансны мэдээллийг байршуулж бие даасан цэстэй байна.</p> <p>-Шилэн дансны мэдээллийг татаж авах, хэвлэх боломжтой.</p>
		<p>1.2. Авлигатай тэмцэх газраас бэлтгэн хүргүүлсэн сурталчилгааны материалыг иргэд, байгууллага, албан хаагчдад түгээх</p>	<p>Мөн Авлигатай тэмцэх газраас зохион байгуулсан сургалт, семинарт яамны ЭБАТ болон яамны албан хаагчдыг тогтмол хамруулж байна. Сургалт семинарийн үеэр өгсөн гарын авлага материалыг яамны удирдлагуудад танилцуулж өгсөн. Долоо хоног бүрийн 5 дах өдөр нийт ажилтнуудад сургалт, мэдээллийг өгдөг. Мөн гарын авлага тараах материалуудыг гаргаж мэдээллийн самбарыг тогтмол ажиллуулж байна. “Нийтийн албан тушаалтнуудад зориулсан гарын авлага” номыг албан хаагчдад түгээсэн.</p>
<p>2</p>	<p>Шинээр боловсруулж байгаа бодлогын баримт бичиг ба нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэр-ийн төслийг олон нийтэд танилцуулах, сонирхогч бүлгүүдтэй харилцан санал солилцох</p> <p>Эрх зүйн үндэслэл:</p> <ul style="list-style-type: none"> • Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2; • Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн 	<p>2.1.Боловсруулж байгаа хууль, Улсын Их Хурал, Зас-гийн газар, иргэдийн Төлөө-лөгчдийн Хурлын тогтоол, нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэр-ийн төсөлд иргэд, олон нийт, сонирхогч бүлгийн санал, шүүмжлэлийг цахим хуудсаар хүлээн авах боломжийг бүрдүүлэх</p>	<p>Яамны вэб сайтын Хэлэлцүүлэг цэс нээж Хууль, дүрэм журмын төслүүдийг байршуулж саналыг info@mm.gov.mn info@mmhi.gov.mn хаягаар хүлээн авах нөцлийг бүрдүүлсэн. mm.gov.mn, mmhi.gov.mn сайтад хуулийн төсөл, журамд иргэдээссанал авах боломжтой. Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль”, Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль”, "Газрын тосны тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль"-ийг УИХ-аар батлуулсан. Шинээр гарсан хуулиудтай нийцүүлэн зарим журам дүрмийг шинээр боловсруулж Засгийн газраар батлуулах ажил яам, агентлагын түвшинд хийгдэж байна.</p>

	<p>тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.5</p>		<p>Яамны цахим хуудсанд Шилэн дансны мэдээллийг байршуулж бие даасан цэстэй байна. -Шилэн дансны мэдээллийг татаж авах, хэвлэх боломжтой. -Тодруулга өгөх албан тушаалтны нэр, холбоо барих хаягийг цахим хуудсанд байршуулсан байна.</p>
		<p>2.2.Боловсруулж байгаа хууль, Улсын Их Хурал, Засгийн газар, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол,нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн төслийг цахим хуудсандаа байршуулсан байх</p>	<p>2016 онд Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч болон нутгийн захиргааны байгууллагын хооронд байгуулах “Байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх тухай гэрээ”-ний загварын төслийг Уул уурхайн яамны үед mm.gov.mn сайтад байршуулан иргэд, ТББ-уудын төлөөллөөс санал авч Засгийн газрын 2016 оны 3 дугаар сарын 28-ны өдрийн 179 дүгээр тогтоолоор батлуулсан. Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны mmhi.gov.mn сайтад байршуулсан байгаа.</p>
		<p>2.3.Дээрх асуудлаар иргэд, олон нийт, сонирхогч бүлгүүдтэй харилцан санал солилцсон байх</p>	<p>Уг гэрээний төслийг боловсруулах ажлын хүрээнд 2015-2016 онд яам, агентлаг, мэргэжлийн холбоод, ТББ-уудын төлөөллийг оролцуулсан 7 удаагийн уулзалт, семинар, хэлэлцүүлгийг зохион байгуулсан. Уул уурхай, газрын тосны салбарын хэмжээнд “Орон нутгийг хөгжүүлэх хамтын ажиллагааны загвар гэрээ”-ний хэлэлцүүлгийг Уул уурхайн яам, Дэлхийн банкны уул уурхайн дэд бүтэц, хөрөнгө оруулалтын төсөлтэй хамтран Улаанбаатар хот болон Өмнөговь, Төв, Дорноговь аймгуудад зохион байгуулсан байна.</p> <p>Хэлэлцүүлэгт ашигт малтмалын тусгай зөвшөөрөл бүхий аймаг, сумдын 150 орчим төлөөлөл, уул уурхайн 60 орчим компаниуд болон иргэний нийгмийн байгууллагын төлөөлөл оролцсон байна.</p> <p>Уул уурхайн салбарын авлигын эрсдлийг бууруулах асуудлаар Уул уурхайн үндэсний ассоциаци, Монгол нүүрс ассоциаци, ТАН эвсэл ТББ-ын төлөөлөл, Авлигатай тэмцэх газар, НҮБ-тай хамтран Уул уурхайн салбарын эрсдлийн үнэлгээ хийлгэн уг үнэлгээнд суурилан Уул уурхайн салбарын авлигын эрсдлийг бууруулах ажлын төлөвлөгөө боловсруулан Уул</p>

			уурхайн сайдаар батлуулан Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын тушаалаар төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлын хэсгийг байгуулан ажиллаж байна. “Хил хягааргүй алхам” ТББ, ИРИМ хараат бус судалгааны байгууллага, Нээлттэй форум нийгэмлэг, НҮБ-ийн Хөгжлийн хөтөлбөр, УУА, “Монгол нүүрс” ассоциацитай идэвхтэй хамтран ажиллаж байгаа болно.
3	Төрийн хяналтынүйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангах Эрх зүйн үндэслэл: • Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3	3.1.Тухайн жилд явуулах хяналт шалгалтын ажлын төлөвлөгөө /төлөвлөгөөт/-г цахим хуудсандаа байршуулсан байх	ХШҮДАГ-ын 2016 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг ТНБД-аар батлуулж төлөвлөгөөний дагуу ажиллаж байна. Яамны дотоод аудитын төлөвлөгөөний хүрээнд Уул уурхайн яамны санхүү, аж ахуйн үйл ажиллагаа болон Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамын албан хаагчдын ажлын цагийн ашиглалт, цагийн бүртгэлийн байдалд хяналт шалгалт, УУС-ын 2016 оны А/63-р тушаалаар Геологийн төв лаборатори, Геологийн судалгааны төвийн 2016 оны үйл ажиллагаанд нэгдсэн аудит хийж тайланг УУХҮЯ-ны удирдлагад танилцуулж ажилласан.Нотлох баримтуудыг хавсаргав.
		3.2. Хийсэн хяналт шалгалтынхаа дүнг олон нийтэд мэдээлсэн байх /цахим хуудсаар, хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлсэн байх/	Уул уурхайн яам нь сайдын эрхлэх асуудлын хүрээний холбогдох эрх зүйн баримт бичгийг 5 ангиллаар хяналтад авч нийт 268 шийдвэрийн 399 заалтад хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн. Тогтоол шийдвэрийн биелэлт ерөнхий дүнгээр 95%-ийн биелэлттэй дүгнэж санал зөвлөмж боловсруулан 2016.01.15-ны өдрийн 1/89 тоотой ЗГХЭГ-т хүргүүлж ажилласан. УУЯ-ны эрхлэх асуудлын хүрээнд 2015 оны жилийн эцсийн байдлаар хууль тогтоомжийн цаг хугацааны хувьд ач холбогдолгүй бөгөөд хэрэгжих боломжгүй болсон, мөн бүрэн хэрэгжсэн УИХ-ын тогтоолын 48 заалт, УИХ-ын байнгын хорооны тогтоолын 6 заалт, ЗГ-ын тогтоолын 54 заалт, ЗГ-ын хуралдааны тэмдэглэлийн 134 заалт, Ерөнхий сайдын захирамжийн 16 заалтыг хүчингүй болгуулах, хаах тухай саналыг жилийн эцсийн эрх зүйн актын тайлангийн хамт хүргүүлсэн. Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан Уул уурхайн яамны 2015 онд хэрэгжүүлсэн нийт 127 арга хэмжээнээс дангаар хэрэгжүүлсэн 18 арга хэмжээний

			<p>биелэлт 87,78%, толгойлон хэрэгжүүлсэн 30 арга хэмжээний биелэлт 85,33%, хамтран хэрэгжүүлсэн 79 арга хэмжээний биелэлт 83,73, нийт арга хэмжээний биелэлт 84,71%-ийн биелэлттэй дүгнэж санал зөвлөмж боловсруулж ажилласан.</p> <p>Монгол Улсын Их Хурлын 2014 оны 07 сарын 01-ний өдрийн 53 дугаар тогтоолоор баталсан, Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2015 онд хөгжүүлэх Үндсэн чиглэлд Уул уурхайн яамны эрхлэх асуудлаар тусгагдсан нийт 6 зорилт, арга хэмжээний биелэлтэд жилийн эцсийн байдлаар хяналт шинжилгээ, үнэлгээ хийхэд 6 зорилт, арга хэмжээнээс 1 арга хэмжээ бүрэн биелсэн, бусад 5 арга хэмжээ хэрэгжих шатандаа 50-аас 90 хувийн биелэлттэй буюу нийт хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлт 81,7%-тай дүгнэж санал зөвлөмж боловсруулж ажилласан.</p> <p>Хууль тогтоомж, бодлогын баримт бичгийн биелэлтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг УУХҮЯ-ны цахим хуудасны “Ил тод байдал” гэсэн бүлэгт Хяналт-шинжилгээ, үнэлгээ гэсэн цэсэнд байршуулж хэрэглэгч, сонирхогч талууд, олон нийт танилцах боломжийг бүрдүүлсэн.</p>
		<p>3.3.Хяналт шалгалтын мөрөөр авсан арга хэмжээ/дүгнэлт, акт, зөвлөмж гаргах, түүний мөрөөр холбогдох арга хэмжээг авсан байдал/-ний үр дүнгийн талаар мэдээлсэн байх</p>	<p>Уул уурхайн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Ашигт малтмалын газрын дарга, Газрын тосны газрын дарга, Менежерүүдийн үр дүнгийн гэрээний биелэлтэд хийсэн хяналт-шинжилгээний нэгдсэн дүн, дүгнэлт, санал зөвлөмжийг удирдлагуудад танилцуулан тайланг ЗГХЭГ-т хүргүүлсэн. Хяналт шалгалтын мөрөөр авсан арга хэмжээ/дүгнэлт, акт, зөвлөмж гаргах, түүний мөрөөр холбогдох арга хэмжээг авсан байдал/-ний үр дүнгийн хариуцсан газар нэгжүүд албан тушаалтнуудад мэдэгдэж зөрчлийг арилгуулсан.Материалыг хавсаргав.</p>
4	Төсвийн орлого, түүний зарцуулалт, гадаадын зээл, тусламж, түүний хуваарилалтыг олон нийтэд тухай бүр мэдээлэх /цахим хуудсаараа/	<p>4.1. Тухайн жилийн төсөв/1 дүгээр сарын 10-ны дотор/</p> <p>4.2. Өмнөх оны төсвийн гүйцэтгэл /4 дүгээр сарын 1-ний дотор/</p>	<p>2016 жилийн төсвийг 2015 оны 12 сард Уул уурхайн сайдын багцын шилэн дансанд, Уул уурхайн яамны сайтад байршуулсан.</p> <p>2016 оны Уул уурхайн сайдын багцын төсвийн гүйцэтгэлийг сайдын багцын шилэн данс, яамны</p>

<p>Эрх зүйн үндэслэл:</p> <ul style="list-style-type: none"> • Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4; • Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4 • Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.9 		сайтад, Уул уурхайн яамны төсвийн гүйцэтгэлийг яамны аппаратын шилэн дансанд 2017 оны 01 дүгээр сарын 8 дотор байршуулсан.
	4.3. Сарын төсвийн гүй-цэтгэл /дараа сарын 8-ны дотор/	Уул уурхайн сайдын төсвийн гүйцэтгэлийн мэдээг сар бүрийн 8-ны дотор багцын болон яамны шилэн дансанд байршуулсан.
	4.4. Улирлын төсвийн гүй-цэтгэл /дараа сарын 8-ны дотор/	Улиралын төсвийн гүйцэтгэлийн мэдээг улирал бүрийн эхний сарын 8-ны дотор Уул уурхайн сайд, яамны шилэн данс, сайтад байршуулан ажилласан.
	4.5. Хагас жилийн төс-вийн гүйцэтгэл /8 дугаар сарын 15-ны дотор/	2016 оны төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгдсэн тайланг 8 дугаар сарын 15-ны дотор Уул уурхайн сайдын Шилэн дансанд, яамны төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг яамны шилэн дансанд байршуулан ажилласан.
	4.6. Хагас жилийн сан-хүүгийн тайлан /8 дугаар сарын 15-ны дотор/	2016 оны төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгдсэн тайланг 8 дугаар сарын 15-ны дотор Уул уурхайн сайдын Шилэн дансанд, яамны төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг яамны шилэн дансанд байршуулан ажилласан.
	4.7. Дараа жилийн төс-вийн төсөл /9 дүгээр сарын 15-ны дотор/	2016 оны төсвийн төслийг 9 дүгээр сарын 15-ны дотор Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын Шилэн данс, яамны сайтад байршуулсан.
	4.8. Жилийн эцсийн сан-хүүгийн тайлан /4 дүгээр са-рын 25-ны дотор/	Уул уурхайн сайдын багцын санхүүгийн нэгдсэн тайланг 4 сарын 25-ны дотор Уул уурхайн сайдын Шилэн данс, яамны сайтад байршуулсан.
	4.9. Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт /4 дүгээр сарын 25-ны дотор/	Үндэсний аудитын газраас Уул уурхайн сайдын багцын нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитлагдсан тайланг дүгнэлтийн хамт Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын багцын Шилэн дансанд байршуулсан.
	4.10. Аудитын тайлан, дүгнэлтэд тусгагдсан асууд-лаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ /7 дугаар сарын 1-ний дотор/	Уул уурхайн сайдын бгцын нэгтгэсэн тайланд өгсөн дүгнэлт, зөвлөмжийн биелэлтийг гарган хуулийн хугацаанд Шилэн дансанд байршуулсан.
	4.11. Төсвийн хэмнэлт, хэлтрэлт, түүний шалтгааны тайлбар /улирал бүр/	Төсвийн хэмнэлт, хэлтрэлт, түүний шалтгааны тайлбарыг улирал бүр төсвийн гүйцэтгэлийн тайлантай хамт гарган Шилэн данс сайтад байршуулан ажиллаж байна.
	4.12. Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт /өөрчлөлт орсноос хойш ажлын 7 хоногийн дотор/	Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт өөрчлөлтийг тухай бүр нь Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын шилэн дансанд байршуулан ажиллаж байна.

		4.13. Төсвийн орлого бүрдүүлэлтийг нээлттэй болгох /татварын орлого, татварын бус орлогын талаарх мэдээ-лэл/	Ашигт малтмал, газрын тосны газрын төсөвт төвлүүлэх орлогын мэдээг сар бүр гарган шилэн данс, яамны сайтад байршуулан ажиллаж байна.
		4.14. Хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд орсон өөрчлөлт / <i>өөрчлөлт орсноос хойш 7 хоногийн дотор</i> /	Хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд орсон өөрчлөлтийг турхай бүр нь шилэн дансанд байршуулан ажиллаж байна. 2016 онд үйлчилгээний хөлсөнд өөрчлөлт ороогүй байна.
		4.15. Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэрийн хамт / <i>гүйлгээ хийснээс хойш 7 хоногийн дотор</i> /	Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэрийн хамт тухай бүр нь яамны Шилэн дансанд байршуулан ажилласан.
		4.16. Байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт / <i>өөрчлөлт орсноос хойш 7 хоногийн дотор</i> /	Тухай бүр нь Шилэн дансанд байршуулан ажиллаж байна.
		4.20. Гадаадын зээл, тусламжаар хэрэгжиж буй төсөл, хөтөлбөр, түүний хэрэгжилтийн талаарх мэдээлэл	Гадаадын зээл, тусламжаар хэрэгжиж буй төсөл, хөтөлбөр, түүний хэрэгжилтийн талаарх мэдээллийг хагас бүтэн жилээр гарган Шилэн дансанд байршуулан ажиллаж байна.
5	<p>Чиг үүргийн дагуу олгож буй зөвшөөрөл, бүртгэлийн үйл ажиллагааг ил тод, нээлттэй байлгах, олон нийтэд танилцах боломжоор хангах</p> <p>Эрх зүйн үндэслэл:</p> <ul style="list-style-type: none"> • Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.5; • Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.8 	<p>5.1. Тухайн байгууллагаас олгож буй зөвшөөрөл /<i>тусгай зөвшөөрөл, лиценз, эрх олгох г.м бусад үйл ажиллагаа эрхлэх зөвшөө-рөл</i>-ийн жагсаалтыг цахим хуудсандаа байршуулах</p> <p>5.2. Дээрх зөвшөөрөл /<i>тусгай зөвшөөрөл, лиценз, эрх олгох г.м бусад үйл ажиллагаа эрхлэх зөвшөө-рөл</i>-ийг олгоход шаардлагатай баримт бичгийн жагсаалт, уг асуудлыг шийдвэр-лэх журмыг цахим хуудсан-даа байршуулах</p> <p>5.3. Тухайн зөвшөөрөл эзэмшигчийн нэр, хаяг, эрх-лэх үйл ажиллагааны чиглэл, зөвшөөрөл олгосон болон дуусгавар болох хугацааг цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байршуулах</p>	<p>Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамнаас олгож байгаа тусгай зөвшөөрийн жагсаалтыг mhi.gov.mn сайтад тусгай зөвшөөрөл гэсэн сайтад байршуулсан.</p> <p>Дээрх тусгай зөвшөөрлүүдийг олгоход шаардлагатай баримт бичгийн жагсаалт, уг асуудлыг шийдвэрлэхтэй холбоотой хууль, журмыг mhi.gov.mn сайтад байршуулсан байгаа.</p> <p>Үнэт металл, эрдэнийн чулуугаар эдлэл хийх үйлдвэрлэл эрхлэх, төмөрлөг боловсруулах, машины үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрөл олгосон байдлыг https://www.mi.gov.mn цахим хуудсанд байршуулсан. Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам байгуулагдсанаас хойш шинээр тусгай зөвшөөрөл нэмж олгоогүй байна. Үйлдвэрлэлийн зориулалтаар тэсэлгээний ажил, үйлчилгээ хийх, тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл</p>

			<p>импортлох, худалдах, үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл болон Газрын тосны болон газрын тосны бүтээгдэхүүний тусгай зөвшөөрөл олгохтой холбогдсон журам, зааврыг УУЯ-ны www.mmhi.gov.mn цахим хуудсанд байршуулсан. Мөн яамны үүдний цахим дэлгэцэнд “Газрын тосны бүтээгдэхүүний тусгай зөвшөөрөлтэй холбогдсон нарийвчилсан журам”-ыг байршуулж, иргэд олон нийтэд мэдээллийг тогтмол түгээж байна. Түүнчлэн 51-260631, 51-263023 дугаарын утсаар өдөр бүр тусгай зөвшөөрөлтэй холбогдсон аливаа асуултад шуурхай хариулт өгч ажиллаж байна. Тусгай зөвшөөрөл авахад шаардлагатай агуулах, ШТС-ын дүгнэлт, бүртгэлийн гэрчилгээний талаар мөн тусгай зөвшөөрөл олгогдсон аж ахуйн нэгжүүдийн талаар Газрын тосны газрын www.pam.gov.mn цахим хуудсанд тухай бүр шинэчлэн оруулж, нийтэд мэдээллэж байна. Холбогдох нотлох баримтуудыг хавсаргав.</p>
		<p>5.4.Чиг үүргийн дагуу нууцад хамаарахаас бусад бүртгэлийн талаарх мэдээллийг цахим хуудсаараа ил тод болгох</p>	<p>Газрын тосны БХГ-ээс бусад тусгай зөвшөөрлийн бүртгэлийн талаар мэдээллийг цахим хуудсанд байршуулсан.БХГ-тэй аж ахуйн нэгжүүдийн жагсаалтыг байршуулсан.</p>
<p>6</p>	<p>Хүний нөөцийн ил тод байдлыг хангах, олон нийтийг түүнтэй танилцах боломжоор хангах</p> <p>Эрх зүйн үндэслэл:</p> <ul style="list-style-type: none"> • Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.5; • Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 8 дугаар зүйл 	<p>6.1.Сул орон тооны зарыг цахим хуудсандаа байршуу-лах /тухай бүр шинэчилсэн/</p>	<p>2016 онд сул ажлын байр нийтэд зарлагдаагүй бөгөөд сул орон тоо гарсан тохиолдолд Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсэгт заасны дагуу яам болон бусад төрийн байгууллагад ажиллаж байгаа төрийн жинхэнэ албан хаагчаас үйл ажиллагааны үр дүн мэргэшлийн түвшингээр нь сонгон шалгаруулах замаар 4 албан хаагчийн материалыг Төрийн албаны зөвлөлд хүргүүлж дүгнэлт гаргуулан томилсон.</p> <p>УИХ-ын 2003 оны 13 дугаар тогтоолын дагуу Геологийн бодлогын хэлтэс, Эдийн засаг, хөрөнгө оруулалтын хэлтэс, Гадаад хамтын ажиллагааны хэлтсийн даргын ажлын байранд томилогдох ажилтныг нөөцөөс сонгон шалгаруулж, нэр дэвшүүлж томилсон. Сонгон шалгаруулалтын материалыг яамны цахим</p>

			хуудсанд хүний нөөцийн ил тод байдалд цэсэнд байршуулсан байгаа. Уул уурхайн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын даргын сул ажлын байранд ажилтны материалыг бүрдүүлж ТАЗ-д хүргүүлэн ТАЗ-өөс нэр дэвшүүлж санал болгосон нэр дэвшигчийн томилон ажилласан. Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Түлшний бодлогын газрын даргын сул ажлын байранд ажилтны материалыг бүрдүүлж ТАЗ-д хүргүүлэн ТАЗ-өөс сонгон шалгаруулалтыг явуулж байна.
		6.2.Сонгон шалгаруулалт явуулах талаар олон нийтийн мэдээллийн хэрэгслээр зарласан байх	Нээлттэй сонгон шалгаруулалт зарлаагүй болно.
7	<p>Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах, түүнтэй танилцах боломжоор хангах</p> <p>Эрх зүйн үндэслэл:</p> <ul style="list-style-type: none"> • Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4; • Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.3, 6.4.4, 6.4.6; • Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 21 дүгээр зүйл, 47 дугаар зүйлийн 47.4, 48 дугаар 	<p>7.1.Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг цахим хуудсандаа байршуулах <i>/1 дүгээр сарын 10-ны дотор/</i></p> <p>7.2.Тендерийн баримт би-чиг, тендер шалгаруулалтыг явуулах журам <i>/тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт/</i>, тендерийн урилгыг цахим хуудсандаа байршуулсан байх</p> <p>7.3. Тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх мэдээлэл, шалгарсанболон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгаа-ныгцахим хуудсанд байр-шуулах</p> <p>7.4. Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худал-дан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжил-тийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаягийг цахим хуудсандаа байршуулах</p> <p>7.5. Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт, шалгалтын дүнг цахим хуудсандаа байршуулах</p>	<p>Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын багцын худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг хуулийн хугацаанд батлуулан шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байршуулж ил тод байдлыг хангав.</p> <p>Тендер шалгаруулалттай холбоотой мэдээллийг цахим хуудсанд байршуулж ил тод байдлын ханган ажиллав.</p> <p>Тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгааныг цахим хуудсанд байршуулж ил тод байдлыг ханган ажиллав.</p> <p>Уул уурхайн яамны цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэрийн хамт гарсан тухай бүр нь шилэн дансанд байршуулан ажилласан.</p> <p>Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт, шалгалтын дүнг цахим хуудсандаа тухай бүрд нь байршуулав.</p>

	зүйлийн 48.5	7.6. Тендерийн үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд тухайн салбарын мэргэжлийн холбоод, хувийн хэвшил, төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулсан байх	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамнаас 2016 онд 2 худалдан авалтыг хийхдээ үнэлгээний хорооны бүрэлдэхүүн бүрд төрийн бус байгууллагын 2 төлөөллийг оролцуулсан.
8	<p>Албан хаагч бүрийн ажил үүргийн хуваарийг тодорхой болгох</p> <p>Эрх зүйн үндэслэл:</p> <ul style="list-style-type: none"> • Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.6 	8.1.Төрийн албан хаагч нэг бүрийн ажил үүргийн хуваарь, ажлын байрны тодорхойлолтыг баталж мөрдүүлсэн байх	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны үйл ажиллагааны стратеги, бүтцийн өөрлөлтийн хөтөлбөрийг боловсруулж Засгийн газрын 2016 оны 09 дүгээр сарын 07-ны өдрийн 81 дүгээр тогтоолоор батлуулан мөрдөн ажиллаж байна. Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаарыг Засгийн Засгийн газрын 2016 оны 07 дугаар сарын 25-ны өдрийн 03 дугаар баталсан ба уг тогтоол гарсантай холбогдуулан Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны зохион байгуулалтын нэгжүүдийн орон тоо, ажлын байрны жагсаалтыг Төрийн нарийн бичгийн даргын 2016 оны 09 дүгээр сарын 05-ны өдрийн Б/14 дүгээр тушаалаар баталсан байна. Мөн Яамны зохион байгуулалтын нэгжүүдийн үйл ажиллагааны стратеги, ажлын байрны тодорхойлолтыг Төрийн албаны зөвлөлийн 2004 оны 34 дүгээр тогтоолоор батлагдсан зааврын Ажжлын хэсэг байгуулан боловсруулж Төрийн нарийн бичгийн даргын 2016 оны Б/13 дугаар тушаалаар батлан мөрдүүлж байна. Тогтоол, шийдвэрүүдийн хуулбарыг хавсаргав.
		8.2.Хариуцсан ажил, үүргийн чиглэлийн талаарх мэдээллийг цахим хуудсаараа нээлттэй болгох	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны зохион байгуулалтын бүтцийн орон тоо, төрийн албан хаагчдын ажлын байрны жагсаалт, чиг үүргийг Төрийн нарийн бичгийн даргын 2015 оны 09 дүгээр сарын 05-ны өдрийн Б/13 дугаар тушаалаар батлан яамны цахим хуудсанд байршуулсан.
9	<p>Авлигатай тэмцэх зорилго бүхий төрийн бус байгуул-лага, иргэдийн сайн дурын хөдөлгөөнийг дэмжих, үйл ажиллагаандаа татан оролцуулах</p> <p>Эрх зүйн үндэслэл:</p> <ul style="list-style-type: none"> • Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.7, 6.1.13; 	9.1.Тодорхой төрлийн үйл ажиллагааны хэрэгжилт, явц байдалд хяналт тавих, судалгаа, дүн шинжилгээ хийх ажлыг иргэний нийгмийн байгууллагаар гүйцэтгүүлсэн байх/1 ба түүнээс дээш/	Уул уурхайн яам, Авлигатай тэмцэх газар, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрөөс захиалан ИРИМ хараат бус судалгааны хүрээлэнгээр Монголын уул уурхайн салбарын эрсдлийн үнэлгээ хийлгэж үнэлгээний тайланг яамны цахим хуудсанд ил тод байдал гэсэн буланд “Авлигын эсрэг хамтдаа” цэсэнд байршуулсан.Судалгааны тайлангийн номыг хавсаргав.

		<p>9.2.Төрийн бус байгууллага, иргэдтэй хамтран хэрэгжүүлсэн үйл ажиллагааны үр дүнгийн талаарх мэдээллийг тайландаа тусгасан байх</p>	<p>Уул уурхайн салбарын авлигын эрсдлийг бууруулах асуудлаар Уул уурхайн үндэсний ассоциаци, Монгол нүүрс ассоциаци, ТАН эвсэл ТББ-ын төлөөлөл, Авлигатай тэмцэх газар, НҮБ-тай хамтран Уул уурхайн салбарын эрсдлийн үнэлгээ хийлгэн уг үнэлгээнд суурилан Уул уурхайн салбарын авлигын эрсдлийг бууруулах ажлын төлөвлөгөө боловсруулан Уул уурхайн сайдаар батлуулан Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын тушаалаар төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлын хэсгийг байгуулан ажиллаж байна. “Хил хягааргүй алхам” ТББ, ИРИМ хараат бус судалгааны байгууллага, Нээлттэй форум нийгэмлэг, НҮБ-ийн Хөгжлийн хөтөлбөр, УУҮА, “Монгол нүүрс” ассоциацитай идэвхтэй хамтран ажиллаж байгаа болно.</p> <p>Орон нутагтай хамтран ажиллах загвар гэрээ"-ний хэлэлцүүлгийг Уул уурхайн яам, Дэлхийн банкны уул уурхайн дэд бүтэц, хөрөнгө оруулалтын төсөлтэй хамтран Улаанбаатар хот болон Өмнөговь, Төв, Дорноговь аймгуудад зохион байгуулсан.</p> <p>Хэлэлцүүлэгт ашигт малтмалын тусгай зөвшөөрөл бүхий аймаг, сумдын 150 орчим төлөөлөл, уул уурхайн 60 орчим компаниуд болон иргэний нийгмийн байгууллагын төлөөлөл оролцсон байна. 2016 онд Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч болон нутгийн захиргааны байгууллагын хооронд байгуулах “Байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх тухай гэрээ”-ний загварын төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, Засгийн газрын 2016 оны 3 дугаар сарын 28-ны өдрийн 179 дүгээр тогтоолоор батлуулсан.</p>
<ul style="list-style-type: none"> Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.6.3 		<p>9.3.Хэрэгжүүлсэн ажил, хамтын ажиллагааны талаар хэвлэл мэдээллийн хэрэгсэл, цахим хуудсаараа мэдээлсэн байх</p>	<p>Уул уурхай яам “Ил тод уул уурхай” хэвлэлийн бага хурлыг 1-5 сарын хооронд 5 удаа зохион байгуулж Уул уурхайн эрхлэх асуудлын хүрээний зорилт арга хэмжээний хэрэгжилт болон цаг үеийн асуудлаар бүх телевиз, радио, хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд ил тод мэдээллийг өгч ажилласан. Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны үйл ажиллагааны талаар болон геологи, уул уурхай, түлш, хүнд үйлдвэрийн салбарын талаар цаг үеийн мэдээллийг яамны цахим</p>

			хуудас болон хэвлэл мэдээллийн хэрэгслээр тогтмол мэдээллэж байна.
10	<p>Авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилтийг хариуцан зохион байгуулах, уг асуудлаар Авлигатай тэмцэх газартай харилцах эрх бүхий албан тушаалтантай байх</p> <p>Эрх зүйн үндэслэл:</p> <ul style="list-style-type: none"> • Авлигын эсрэг хууль 6 дугаар зүйлийн 6.1.8; • Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.2 	<p>10.1.Эрх бүхий албан тушаалтан /ЭБАТ/-ыг томилсон байх, урамшуулал өгдөг эсэх</p>	<p>Монгол Улсын Авилгын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.8 дахь хэсэг, Яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.6.9 дэх хэсэг, Нийтийн албанд болон нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргээлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.2 дахь хэсэг, 23 дугаар зүйлийн 23.8 дахь хэсэг, Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны 2012 оны 05 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтын 3.1 дэх хэсэгт заасныг тус тус үндэслэн ЭБАТ-наар ТЗУГ-ын ахлах мэргэжилтэн Ж.Дэмчигсүрэнг Төрийн нарийн бичгийн даргын 2016 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн Б/38 дугаар тушаалаар үргэлжлүүлэн томилж үндсэн цалингийн 40 хувьтай тэнцэх урамшуулал олгож байна. Авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах, уг асуудлаар Авлигатай тэмцэх газартай харилцах талаар Ажлын байрны тодорхойлолтод нь тусган ажиллаж байна.Төрийн нарийн бичгийн даргын тушаал, Ажлын байрны тодорхойлолтыг хавсаргав.</p>
		10.2.ЭБАТ-ын гүйцэтгэх чиг үүргийг ажлын байрны тодорхойлолт болон ажил үүргийн хуваарьт тусгасан байх	Төрийн нарийн бичгийн даргын 2016 оны Б/13 дугаар тушаалаар батлагдсан ажлын байрны тодорхойлолтод Салбарын хүний нөөцийн бодлого, төлөвлөлт, Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөл, шагнал, урамшуулал, Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, ХАСХОМ хариуцсан ахлах мэргэжилтэн гэж тусган ажлын чиг үүргийг тодорхойлон хэрэгжүүлж байна
		10.3.Авлигатай тэмцэх газраас зохион байгуулсан сургалтад хамрагдсан байх	<p>Авлигатай тэмцэх газраас зохион байгуулсан сургалтуудад цаг тухай бүр нь бүрэн хамрагдсан болно.Үүнд:</p> <p>-2016.01.07-2016.01.08-ны өдрүүдэд зохион байгуулсан Төрийн захиргааны болон нутгийн захиргааны төв байгууллагын мэдүүлэг бүртгэх, хадгалах, хянах эрх бүхий албан тушаалтнуудад</p>

			<p>зориулсан сургалт семинар</p> <p>-Шударга байдлын үнэлгээ-2015 сэдэвт сургалт, семинар ХШУДАГ-ын ахлах мэргэжилтэнтэй хамт оролцсон.</p>
		10.4.ЭБАТ-ын үйл ажиллагааг үнэлэх	<p>ЭБАТ-ын 2015 оны үйл ажиллагааны тайлангаа АТГ-т хугацаанд хүргүүлж үнэлүүлсэн. АТГ-аас ЭБАТ-ны үйл ажиллагааг “А” буюу маш сайн гэсэн үнэлгээ авсан. Шилдэг ажилтнаар шалгарч АТГ-ын даргын өргөмжлөл, цомоор шагнуулсан. АТГ-аас 5-р сард Уул уурхайн яамны хууль тогтоомжийн хэрэгжилтэд хийсэн шалгалтаар Эрх бүхий албан тушаалтан Ж.Дэмчигсүрэнгийн үйл ажиллагааг хангалттай түвшинд хэрэгжиж байна гэж дүгнэсэн байна.</p>
11	<p>Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх ёс зүйн дүрмийг тогтоон мөрдүүлэх</p> <p>Эрх зүйн үндэслэл:</p> <ul style="list-style-type: none"> • Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.1, 7.1.2, 7.2.4, 7.2.5, 10-22 дугаар зүйл, 29 дүгээр зүйл; • Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.9, 6.8, 6.1.6 	<p>11.1.Ёс зүйн дүрмийн төсөлд Авлигатай тэмцэх газраас өгсөн саналыг тусгасан байх</p>	<p>Яамны дэргэд Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг хянах Ёс зүйн хороог яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын даргаар ахлуулан 7 хүний бүрэлдэхүүнтэй Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн 2015 оны 01 дүгээр тогтоолоор шинээр байгуулан ажиллуулж байна. Уул уурхайн яамны үед Уул уурхайн яамны албан хаагчдын ёс зүйн дүрмийг шинээр боловсруулан Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар батлуулан хэрэгжүүлж ажилласан. Одоо Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам шинээр байгуулагдсантай холбогдуулан шинэчлэн боловсруулж байна.</p>
		11.2.Ёс зүйн дүрмийг батлах, мөрдүүлэх/албан хаагчдад танилцуулсан байдал/	<p>Засгийн газрын 2010 оны 288 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн захиргааны албан хаагчдыг ёс зүйн дүрэм”-ийг яамны төрийн албан хаагчдад танилцуулж үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.</p>
		11.3.Зөрчлийн талаарх мэдээлэл хүлээн авах нөхцөл /тогтмол утас ажиллуулах, цахим хуудсанд байршуулах, шуудангаар, биечлэн, хайрцаг байршуулах г.м/-ийг бүрдүүлсэн байх	<p>Угтах үйлчилгээний ажилтан ажиллуулж иргэдээс өргөдөл гомдол хүлээн авах хайрцаг, 264373 дугаарын утсыг яамны үүдний зааланд байршуулсан. Уул уурхайн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2013.05.07-ны өдрийн 58 дугаар тушаалаар “Уул уурхайн яамны нэг цэгийн үйлчилгээ үзүүлэх үйл</p>

			ажиллагааг зохицуулах журам”-ыг батлуулан хэрэгжүүлж байна. Мөн ЭБАТ -ны утас, өрөөний дугаарыг цахим хуудсанд байршуулсан.
		11.4.Зөрчил үүссэн буюу үүсч болзошгүй тохиолдолд урьдчилан сэргийлэх арга хэмжээ /Зөвлөмж/-г авах	Зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар албан хаагчдад тогмол өгч зөвлөмж, мэдээллийг өгч ажиллаж байна. Уул уурхайн сайдын 2016 оны 07 дугаар сарын 21-ний өдрийн 1/1319 тоот албан бичгээр Ашигт малтмалын газар болон газрын тосны газрын дарга нарт “Авлигаас урьдчилан сэргийлэх ажлын эрчимжүүлэх тухай” үүрэг даалгавар зөвлөмж өгч хэрэгжилтийг тооцон ажиллаж байна. Уул уурхайн сайдын албан тоот болон хэрэгжилтийг ирүүлсэн Ашигт малтмал, газрын тосны газрын даргын албан тоотыг хавсаргав.
		11.5.Зөрчил илэрсэн тохиолдолд хуульд заасан хариуцлагыг хүлээлгэсэн байх	Ямар нэгэн зөрчил илрээгүй байна. Бүх албан хаагчдын 2014, 2015 оны ХАСХОМ-ийг АТГ-аас шалгаж илэрсэн зөрлийг арилган биелэлтийг Төрийн нарийн бичгийн даргын албан тоотоор АТГ-т хүргүүлсэн. Албан бичгийг хавсаргав.
		11.6.Ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг хамт олонд мэдээлсэн байх	Ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг яамны хамт олонд танилцуулж зөвлөмж өгч ажиллаж байна. 2016 онд ёс зүйтэй холбоотой зөрчил гараагүй болно.
12	Давхар ажил эрхлэх боломжтой эсэхийг шийдвэрлэх Эрх зүйн үндэслэл: • Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.6, 19 дүгээр зүйл	12.1.Хууль болон Засгийн газраас зөвшөөрсөн давхар эрхэлж болох ажлын жагсаалтыг гаргаж, албан хаагчдад танилцуулсан байх 12.2.Давхар ажил эрхлэлтийн талаарх судалгаатай байх, давхар ажил эрхлэх тохиолдолд зөвшөөрөл олгодог байх	Төрийн албан тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.6-дахь заалт, болон Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 18 -20 дугаар зүйлд заасан давхар ажил эрхлэлттэй холбогдсон хязгаарлалтыг яамны албан хаагчдад танилцуулсан. Жагсаалтыг гаргаж танилцуулсан. Давхар эрхлэх боломжтой ажлын жагсаал, Давхар ажил эрхлэлтийн судалгааг хавсаргав.
13	Байгууллагын удирдлагаас гаргаж буй шийдвэрийн ил тод, нээлттэй байдлыг хангах Эрх зүйн үндэслэл:	13.1.Удирдлагын шийдвэрийн ил тод, нээлттэй байдлыг хангах нөхцөл, боломжийг бүрдүүлсэн байх /цахим хуудсаар/	Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд, ТНБД-ын төрийн болон байгууллагын нууцад хамааруулснаас бусад тушаалыг mm.gov.mn, mmhi.gov.mn сайтад тогтмол байршуулж байна. Хүний нөөцтэй холбоотой ТНБД-ын тушаалуудыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны цахим хуудсанд “Хүний нөөцийн ил тод байдал” гэсэн цэсэнд байршуулсан байгаа.

	<ul style="list-style-type: none"> • Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.10; • Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.4, 9.1.5 	<p>13.2.Удирдлагаас гаргасан төрийн болон байгууллагын нууцад хамааруулснаас бусад шийдвэр /тушаал, захирамж/-ийг цахим хуудсандаа байршуулах</p>	<p>Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд, ТНБД-ын төрийн болон байгууллагын нууцад хамааруулснаас бусад тушаалыг mm.gov.mn, mmhi.gov.mn сайтад тогтмол байршуулж байна. Хүний нөөцтэй холбоотой ТНБД-ын тушаалуудыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны цахим хуудсанд “Хүний нөөцийн ил тод байдал” гэсэн цэсэнд байршуулсан байгаа.</p>
		<p>13.3.Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж /хуульчилсан акт/, дүрэм, журам, зааврыг цахим хуудсандаа байршуулах</p>	<p>Яамны үйл ажиллагаанд мөрдөж байгаа бүх журам дүрэм, зааврын ил тод байдлыг хангаж mm.gov.mn сайтад тогтмол байршуулж байна.</p> <p>Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамнаас үйлчилгээ авахад шаардлагатай бичиг баримтын жагсаалтыг гаргасан. Уг жагсаалтыг яамны цахим хуудас болон мэдээллийн самбарт байршуулсан. Цахим хуудасны мэдээллийг тухай бүр шинэчлэж байгаа. Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж, дүрэм, журам, зааврын жагсаалт, эмхтгэлийг хэвлэн гаргасан.</p> <p>Яамны үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж, дүрэм, журам, зааврын жагсаалтыг цахим хуудсанд байршуулсан.</p> <p>Мэдээллийг тухай бүр шинэчилж байгаа Яамны веб сайтаас үзэх</p>
		<p>13.4.Үйлчлүүлэгчээс авч буй төлбөр, хураамжийг цахим хуудсандаа байршуулах</p>	<p>Үйлчлүүлэгчээс авч буй төлбөр, хураамж байхгүй болно.</p>
<p>14</p>	<p>Иргэдийн өргөдөл /санал, мэдэгдэл/, гомдол, хүсэлтийг хүлээн авах, шийдвэрлэх шат дамжлагыг цөөрүүлэх, зөрчлийн талаарх мэдээллийг хүлээн авч шалгах</p> <p>Эрх зүйн үндэслэл:</p> <ul style="list-style-type: none"> • Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.11; • Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.2; • Нийтийн албанд нийтийн 	<p>14.1.Хууль тогтоомжоор тогтоосон өөрийн эрхлэх асуудлын хүрээг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлж, сурталчилсан байх</p>	<p>Уул уурхай яам “Ил тод уул уурхай” хэвлэлийн бага хурлыг 1-5 сарын хооронд 5 удаа зохион байгуулж Уул уурхайн сайдын эрхлэх асуудлын хүрээний зорилт арга хэмжээний хэрэгжилт болон цаг үеийн асуудлаар бүх телевиз, радио, хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд ил тод мэдээллийг өгч ажилласан. Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны үйл ажиллагааны талаар болон геологи, уул уурхай, түлш, хүнд үйлдвэрийн салбарын талаар цаг үеийн мэдээллийг яамны цахим хуудас болон хэвлэл мэдээллийн хэрэгслээр тогтмол мэдээллэж байна.</p>
		<p>14.2.Өргөдөл /санал, мэдэгдэл/, гомдол, хүсэлт, мэдээлэл хүлээн авах нөхцөлийг бүрдүүлсэн байх (утас, хайрцаг, санал</p>	<p>Өргөдөл /санал, мэдэгдэл/, гомдол, хүсэлт, мэдээлэл хүлээн авах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор Угтах үйлчилгээний ажилтан ажиллуулж иргэдээс өргөдөл</p>

	<p>болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.3;</p> <ul style="list-style-type: none"> Иргэдээс төрийн байгууллага албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомд-лын шийдвэрлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 8, 9 дэх заалт, 19 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг 	<p>хүсэлтийн дэвтэр, факс, цахим, бичгээр, амаар г.м хэлбэрээр)</p>	<p>гомдол хүлээн авах хайрцаг, 264373 дугаарын утсыг яамны үүдний зааланд байршуулсан. Уул уурхайн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2013.05.07-ны өдрийн 58 дугаар тушаалаар “Уул уурхайн яамны нэг цэгийн үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг зохицуулах журам”-ыг батлуулан хэрэгжүүлж байна. Мөн Засгийн 11-11 төвөөр ирүүлсэн санал хүсэлтийг тухай бүр хүлээн авч шийдвэрлэж ажилласан.Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам шинээр байгуулагдсанаар Өргөдөл /санал, мэдэгдэл/, гомдол, хүсэлт, мэдээлэлийн асуудлыг ТЗУГ-ын ахлах мэргэжилтэн Я.Бадрахад хариуцуулан ажиллаж байна.</p>
		<p>14.3.Үйлчилгээ, захидал харилцааны асуудал хариуцсан албан хаагчийн нэр, албан тушаал, ажиллах журам, харилцах утас, иргэдийг хүлээн авч уулзах цагийн хуваарийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байршуулах</p>	<p>Угтах үйлчилгээний ажилтны нэр, утас, Уул уурхайн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2013.05.07-ны өдрийн 58 дугаар тушаалаар “Уул уурхайн яамны нэг цэгийн үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг зохицуулах журам”-ыг Уул уурхайн яамны цахим хуудсанд байршуулсан.Одоо шинэ яам байгуулагдсанаар шинэчлэгдэж байгаа.</p>
		<p>14.4.Иргэдийн өргөдөл /санал, мэдэгдэл/, гомдол, хүсэлт, мэдээллийг шийдвэрлэсэн талаар хэвлэл, мэдээллийн хэрэгслээр тогтмол хугацаанд мэдээлсэн байх</p>	<p>Яамны цахим хуудсанд өргөдөл, гомдолийн талаарх цонх нээн ажиллуулж, шийдвэрлэсэн байдлыг нийтэд тогтмол мэдээдэг. 2016.11.11-ний байдлаар 166 өргөдөл, гомдлыг хүлээн авч шийдвэрлэсэн бөгөөд хэрэгжилт 81,74 хувьтай байна.</p>
<p>15</p>	<p>Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах</p> <p>Эрх зүйн үндэслэл:</p> <ul style="list-style-type: none"> Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.12; Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.1 	<p>15.1.Авлигад өртөх эрсдэлтэй ажил, албан тушаал, үйлчилгээний жагсаалтыг гаргах, уг жагсаалтыг гаргах-даа тодорхой судалгаа, шин-жилгээнд тулгуурласан байх</p>	<p>Яамны хэмжээнд Авлигад өртөх эрсдэлтэй ажил, албан тушаал, үйлчилгээний жагсаалтыг гаргасан. Уг жагсаалтыг гаргахдаа ажлын онцлог, байдлыг үндэслэн гаргасан.</p>
		<p>15.2.Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах чиглэлээр холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх /хүнд суртал, чирэгдлийг багасгах, сөрөг үзэгдлийг хаах, ашиг сонирхлын зөрчлийн мэдүүлгийг хянах, мэдэгдэл гаргах, албан хаагчийн ажлын байрыг сэлгүүлэх зэрэг үр дүнтэй арга хэмжээг хэрхэн зохион байгуулсан г.м/</p>	<p>Хүнд суртал, чирэгдлийг багасгах, сөрөг үзэгдлийг хаах, ашиг сонирхлын зөрчлийн мэдүүлгийг хянах, мэдэгдэл гаргах, албан хаагчийн ажлын байрыг сэлгүүлэх зэрэг үр дүнтэй арга хэмжээг авч хэрэгжүүлэх зорилгоор дараах ажлуудыг хийсэн байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - НҮБ, Авлигатай тэмцэх газартай хамтран IRIM хараат бус судалгааны байгууллагаар Монголын Уул уурхайн салбарын авлигын эрсдлийн үнэлгээ хийлгэсэн - Уул уурхайн салбарын авлигын эрсдлийг бууруулах төлөвлөгөөг боловсруулж Уул уурхайн сайдаар

			<p>батлуулсан.</p> <ul style="list-style-type: none"> - Уул уурхайн салбарын авлигын эрсдлийг бууруулах төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлын хэсгийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын тушаалаар байгуулан ажиллуулж байна. - Энэ төлөвлөгөөний хүрээнд төрөөс иргэдэд үзүүлж байгаа үйлчилгээг хүнд суртал чирэгдэлгүй, шуурхай болгох зорилгоор салбарын хууль эрх зүйг боловсронгуй болгохоор НҮБ-аас зөвлөхийн сонгон шалгаруулалт зарлан зөвлөхийг сонгон ажиллуулж байна. - “Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн дүрэм”, “Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн бүрэлдэхүүн”, “Шинжээчийн ажлын хөлс аргачлал”-ыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын тушаалаар шинэчлэн батлан мөрдөж байна. - Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч болон нутгийн захиргааны байгууллагын хооронд байгуулах “Байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх тухай гэрээ”-ний загварын төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, Засгийн газрын 2016 оны 3 дугаар срын 28-ны өдрийн 179 дүгээр тогтоолоор батлуулсан. - Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны үйл ажиллагааны стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг шинээр боловсруулж Засгийн газрын 2016 оны 81 дүгээр тогтоолоор батлуулсан. - Яамны дотоод зохион байгуулалтын нэгжүүдийн бүтэц, орон тоо, ажлын байрны жагсаалтыг баталж албан хаагчдын ажлын байрыг сэлгүүлэн ажиллуулах зарчмыг баримтлан ажиллаж байна. Үүнд: АМГТГ-аас 2 албан хаагчийг яаманд яамнаас 4 албан хаагчийг АМГТГ-т сэлгүүлэн ажиллуулснаас гадна газар хэлтсүүдийн хооронд зарим албан хаагчдыг сэлгүүлэн томилж ажиллуулж байна.
	<p>Авлигатай тэмцэх газраас бүрэн эрхийнхээ дагуу гаргасан шийдвэрийг биелүүлэх</p>	<p>16.1.Авлигатай тэмцэх газраас хүргүүлсэн Зөвлөмжийн биелэлт, зохион байгуулсан арга хэмжээ</p>	<p>АТГ-ын 2016 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн 02/3620 тоотоор ирүүлсэн “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар ирүүлсэн зөвлөмжийн дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тухай Уул уурхайн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2016 оны 06</p>

	<p>Эрх зүйн үндэслэл:</p> <ul style="list-style-type: none"> • Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.6, 6.7, 18 дугаар зүйлийн 18.4.2, 29 дүгээр зүйлийн 29.4; • Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2 		дугаар сарын 17-ны өдрийн 3/1157 тоот албан бичгийг 24 хуудас хавсралт материалын хамт АТГ-т хүргүүлсэн. Албан тоотыг хавсаргав.
		16.2.АТГ-ын мөрдөн байцаагчаас гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг арилгуула-хаар хүргүүлсэн мэдэгдлийн биелэлт, зохион байгуулсан арга хэмжээ	АТГ-ын мөрдөн байцаагчаас гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг арилгуулахаар ирүүлээгүй болно.
		16.3.АТГ-аас зөрчил арилгуулахаар хүргүүлсэн албан бичгийн биелэлт, зохион байгуулсан арга хэмжээ	АТГ-ын 2016 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн 02/3620 тоотоор ирүүлсэн “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар ирүүлсэн зөвлөмжийн дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тухай Уул уурхайн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2016 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн 3/1157 тоот албан бичгийг 24 хуудас хавсралт материалын хамт АТГ-т хүргүүлсэн. Албан тоотыг хавсаргав.
		16.4.АТГ-аас хариуцлага тооцож, арга хэмжээ авахуулахаар хүргүүлсэн албан бичгийн биелэлт	АТГ-аас хариуцлага тооцож, арга хэмжээ авахуулахаар албан бичиг ирүүлээгүй байна.
		16.5.Авлига гарах нөхцөл боломжийг бүрдүүлсэн гэж үзсэн дүрэм, журам, заавар, шийдвэрийг өөрчлөх буюу хүчингүй болгосон эсэх	Авлига гарах нөхцөл боломжийг бүрдүүлсэн гэж үзсэн дүрэм, журам, заавар, шийдвэрийг өөрчлөх буюу хүчингүй болгоогүй.
		16.6.АТГ-ын даргын 2012 оны 74 дүгээр тушаалаар батлагдсан “Албан тушаалтан өөрт ногдуулсан сахилгын шийтгэлийн талаарх мэдээллийг холбогдох этгээд болон нийтэд өөрийн зардлаар хүргэх арга хэмжээний журам”-ыг хэрэгжүүлэх чиглэлээр авсан арга хэмжээ	Ийм асуудал гараагүй болно.
Авлигатай тэмцэх санал, санаачлага			
Дэд хэсэг	Хийх ажлын агуулга	Гүйцэтгэлийн үзүүлэлт	Гүйцэтгэл
17	Авлигын эсрэг соён гэгээрүүлэх, авлигатай тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэм-жээг боловсруулж хэрэгжүү-лэх	17.1.Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө баталж, хэрэгжүүлсэн байх	Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан АТГ-ийн саналыг авч тусган Төрийн нарийн бичгийн даргаар батлуулан АТГ-т хүргүүлэн АТГ-ын цахим хуудас болон яамны цахим хуудсанд байршуулсан.
	Эрх зүйн үндэслэл:	17.2.Төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээ цаг, хугацаандаа хэрэгжсэн байх	Төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээнээс нь хугацаандаа хэрэгжсэн байна.
		17.3.Хэрэгжилтийн тайланг тогтсон хугацаа	Төлөвлөгөөний биелэлтийг холбогдох нотлох

	<ul style="list-style-type: none"> Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.5, 7.6.1, 7.6.2; 	<p>/жил бүрийн 11 сарын 15-ны дотор/-нд АТГ-т хүргүүлсэн байх</p> <p>17.4.Төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд гарч буй хүндрэл бэрхшээл, ололт амжилт, хүрсэн үр дүн, цаашид хэрэгжүүлэх ажлын саналыг тайланд тусгасан байх</p>	<p>баримтын хамт гарган 2016 оны 11 дүгээр сарын 11-нд АТГ-т хүргүүлсэн.</p> <p>Төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлэхэд санхүүгийн асуудал нөлөөлж байна. Мэдээллийн ил тод нээлттэй байдал өмнөх жилээс сайжирсан.</p>
18	<p>Байгууллагын удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзлэл, хүчин чармайлт</p>	<p>18.1.Авлигын эсрэг төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн байгууллагаас гаргасан санал, санаачилга /уриа, уриалга, мэдэгдэл, амлалт г.м/-д нэгдсэн байдал</p>	<p>“Авлигын эсрэг хамтдаа” уриатай ажиллаж байна. Авлигын эсрэг хамтдаа гэсэн тусгай самбар ажиллуулж Авлигаас урьдчилан сэргийлэх талаар хууль тогтоомж мэдээллийг тогтмол байршуулж сурталчилж байна. Авлигын эсрэг төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн байгууллагаас гаргасан санал, санаачилгыг дэмжин ажиллаж байна.</p> <ul style="list-style-type: none"> - НҮБ, Авлигатай тэмцэх газартай хамтран IRIM хараат бус судалгааны байгууллагаар Монголын Уул уурхайн салбарын авлигын эрсдлийн үнэлгээ хийлгэсэн - Уул уурхайн салбарын авлигын эрсдлийг бууруулах төлөвлөгөөг боловсруулж Уул уурхайн сайдаар батлуулсан. - Уул уурхайн салбарын авлигын эрсдлийг бууруулах төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлын хэсгийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын тушаалаар байгуулан ажиллуулж байна. - Энэ төлөвлөгөөний хүрээнд төрөөс иргэдэд үзүүлж байгаа үйлчилгээг хүнд суртал чирэгдэлгүй, шуурхай болгох зорилгоор салбарын хууль эрх зүйг боловсронгуй болгохоор НҮБ-аас зөвлөхийн сонгон шалгаруулалт зарлан зөвлөхийг сонгон ажиллуулж байна. - “Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн дүрэм”, “Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн бүрэлдэхүүн”, “Шинжээчийн ажлын хөлс аргачлал”-ыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын тушаалаар шинэчлэн батлан мөрдөж байна. -Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч болон нутгийн захиргааны байгууллагын хооронд байгуулах “Байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх тухай гэрээ”-ний загварын

			төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, Засгийн газрын 2016 оны 3 дугаар сарын 28-ны өдрийн 179 дүгээр тогтоолоор батлуулсан.
		18.2.Удирдах албан тушаалтнуудын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзлэл, хүчин чармайлт, санаачилга, тэдний үлгэр жишээ байдал	Сайд, дэд сайд сайд. Төрийн нарийн бичгийн дарга болон газар, хэлтсийн дарга нар авлигатай тэмцэх хүсэл эрмэлзлэл, хүчин чармайлт, санаачилга гарган ажиллаж байгаа
		18.3.Авлигын эсрэг арга хэмжээнд зориулан тусгай-лан хөрөнгө гаргасан эсэх /зарцуулалт/	Авлигын эсрэг арга хэмжээнд зориулан төсвийн төсөл жил бүр хийж өгдөг боловч Сангийн яамнаас хасагддаг учир тусгайлан гаргасан хөрөнгө бхйгүй болно.
		18.4.Удирдлагын хүсэл, эрмэлзлэл, хүчин чармайлт, үлгэр жишээ байдлын талаар ажилтнуудаас өгсөн үнэлгээ	-
19	Албан хаагчдын шударга байдал ба түүнийг нэмэгдүүлэх	19.1.Албан тушаалтан, албан хаагчдын шударга байдлыг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээ /шударга ёс, ёс зүй, сонирхлын зөрчлийн талаарх сургалт, хэлэлцүүлэг, ярилцлага, өдөрлөг, зөвлөмж өгөх г.м/-г авах	Авлигын эсрэг хууль, Нийтийн албан хувийн ашиг сонирхлыг зохицуулах болон ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх хууль, УИХ-ын Хууль зүйн байнгын хорооны 2014 оны 20 дугаар тогтоол, Авилгаас урьдчилан сэргийлэх чиглэлээр АТГ-тай хамтран 2 удаа сургалт зохион байгуулсан. Яамны аппаратын чадавхийг дээшлүүлэх хүрээнд: <ul style="list-style-type: none"> Архив, бичиг хэргийн стандарт сэдвээр Архивын ерөнхий газрын Мэргэжил арга зүйн удирдлагын газрын дарга Б.Цэндсүрэнг урьж нийт албан хаагчдад сургалт хийсэн. Хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэрийг боловсронгуй болгох нь сэдвээр Захиргааны ерөнхий хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан МУИС-ын ХЗС-ийн Нийтийн эрх зүйн танхимын багш Т.Мөнх-Эрдэнийг урьж сургалт зохион байгуулсан.
		19.2.Албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг үнэлэх үйл ажиллагааг үнэн зөв, шударга болгох чиглэлээр авсан арга хэмжээ	2016 онд 1-р сарын 20-ны дотор яамны төсвийн шууд захирагч, нэгжийн менежер, төрийн албан хаагчидтай үр дүнгийн гэрээ байгуулан ажилласан. 2015 оны жилийн эцсийн байдлаар 50 төрийн ахиргааны албан хаагчтай үр дүнгийн гэрээ байгуулан үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлж дүгнэснээс маш сайн буюу "А" үнэлгээтэй 33, сайн буюу "В" үнэлгээтэй 17, 2016 оны эхний хагас жилийн байдлаар 50 төрийн захиргааны албан хаагчтай үр дүнгийн гэрээ байгуулж

			үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлж дүгнэснээс маш сайн буюу "А" үнэлгээтэй 50 албан хаагч байна.
		19.3.Байгууллагын дотоод аудит, хяналт шалгалтын хүрээнд илрүүлсэн авлигын зөрчил, авсан арга хэмжээ	Байхгүй
		19.4.Бусад байгууллага, иргэдийн гомдлоор илэрсэн зөрчил, авсан арга хэмжээ	Байхгүй
		19.5.Авлигатай тэмцэх газрын шалгалтаар илэрсэн авлигын гэмт хэрэг /шүүхээр шийдвэрлэгдсэн/ ба бусад зөрчил	Байхгүй

УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ